

БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Дэлхийн хамгийн хүйтэн хотоор тодорсон Улаанбаатар хотын захын хороололд байрлалтай дулааны төвлөрсөн шугаманд холбогдоогүй сургууль, цэцэрлэг эмнэлэг, орон сууц болон үйлдвэр аж ахуйн газруудыг дулааны эрчим хүчээр зайлшгүй хангах шаардлагын үндсэн дээр Нийтийн аж ахуй үйлчилгээний яамны /хуучнаар/ мэдэлд байсан 19 халаалтын зуухыг БНМАУ-ын СнЗ-ийн 1990 оны 04 дүгээр сарын 142 дугаар тогтоолоор Түлш эрчим хүчний яамны мэдэлд шилжүүлсэнээр тус яамны сайдын 1990 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 32 дугаар тушаалаар Улаанбаатар дулааны шугам сүлжээний газрын харьяалалд “Халаалтын зуухны ашиглалтын төв” нэртэйгээр байгуулж, зуухнуудын нэгдсэн зохион байгуулалтанд орсон үйл ажиллагаа нь 1990 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхэлсэн байна.

Халаалтын зуухны ашиглалтын төв нь бүтэц зохион байгуулалтын хувьд захиргаа, үйлдвэрлэл, санхүү, үйчилгээний хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан.

Анх зохион байгуулагдсан үедээ 19 зуухны усан хангамжийг зөөврөөр хангаж байсан ба 20 гаруй ус тээврийн авто машинтай өөрийн авто бааз, засвар үйлчилгээний цехтэй ажиллаж байжээ.

1993 оноос зуухны тоо 25 болж нийт 370 гаруй ажилтан, ажиллагсадтайгаар дулааны эрчим хүч үйлдвэрлэж, үйл ажиллагаа нь өргөжиж байсан байна.

Халаалтын зуухны ашиглалтын төвийг Түлш эрчим хүчний яамны сайдын 1993 оны 16 дугаар тушаалаар Эрчим хүчний удирдах газрын мэдэлд шилжүүлжээ.

Монгол улсын их хурлаар 1996 онд батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу 1997 онд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн харьяанд шилжсэн. Нийслэлийн нийгэм-эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд халаалтын зуухны ашиглалтын төвийн чиг үүрэг нэмэгдэж байгааг харгалзан нийслэлийн засаг даргын 2001 оны 38 дугаар захирмжаар “Халаалтын зуухны ашиглалтын газар” нэртэйгээр зохион байгуулж, эрх үүргийг нь нэмэгдүүлсэн.

Халаалтын зуухнуудыг зах зээлийн харилцаанд шилжүүлж хувийн хэвшлийн компануудад хариуцуулах бодлогын хүрээнд 2003-2005 оны хооронд манай харьяаны 9, 10, 16, 22, 65,87 дугаар зуухнуудыг Хоёулаа Хүү ХХКомпанид, 11,15, 19, 20, 23, 30 дугаарзуухнуудыг Түшигт Хангай ХХКомпанид, 42, 105, 67, 7, 134, 107, 72, 17, 57, 35, 49 дүгээр халаалтын зуухнуудыг “Ану Сервис” ХХКомпанид менежментийн гэрээгээр шилжүүлж, технологийн шинэчлэлт бүрэн хийлгэсэн.

Улаанбаатар хотын хүн амын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр захын хороололд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төр захиргааны байр олноор баригдаж халаалтын

зуухнуудын тоо жил бүр нэмэгдэж байгаа, хувийн хэвшлийн компануудын хариуцан ажиллуулж байгаа халаалтын зуухнуудын үйл ажиллагаанд хүүхэд, иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийн үүднээс хяналт тавих, шаардлагатай үед туслах, халаалтын зуухнуудын техник технологийн шинэчлэл, үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах шаардлагын үүднээс Нийслэлийн засаг даргын 2005 оны 22 дугаар захирамжаар Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газар нэртэйгээр өөрчлөн зохион байгуулж, эрхлэх ажлын цар хүрээ өргөжин тэлсэн байна.

Хотын захын хороололд байрлах сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хороо, орон сууцны хэрэглэгчдийг дулаанаар ханган ажиллаж байгаа зарим компануудын үйл ажиллагаанд шалгалт хийхэд мэргэжил, ажлын чадвар дутагдсанаас удаа дараа аваар гаргасан, хэрэглэгчдийн ая тухтай байдлыг алдагдуулж байсан менежментийг гэрээ, тусгай зөвшөөрлийг цуцалж Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд байрлах УС-15, Хан-Уул дүүргийн 12, 13 дугаар хороонд байрлах 24, 14 дүгээр халаалтын зуухнуудыг Нийслэлийн засаг даргын 2009 оны 390 дүгээр захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2009 оны 412 дугаар тушаалаар, Сонгинохайрхан дүүргийн 104, Чингэлтэй дүүргийн 61, Сүхбаатар дүүргийн 58 дугаар сургуулиудын халаалтын зуухнуудыг Нийслэлийн засаг даргын 2011 оны 594 дүгээр захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2011 оны 536 дугаар тушаалаар Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газрын мэдэлд бүрэн шилжүүлсэнээр сүүлийн жилүүдэд хэрэглэгчид нь тав тухтай өвөлжиж байна.

Одоо манай хамт олон Улаанбаатар хотын захын хороололд байрлах 96 газрын 180 гаруй халаалтын зуухнуудын өдөр тутмын үйл ажиллагаа, , техник-технологийн шинэчлэлтийг нь мэргэжлийн удирдлагаар хангах, агаарын бохирдолтой холбогдуулан халаалтын зуухнуудад түлэх төрөл бүрийн түлшинд туршилт хийж төр захиргааны удирдлагуудыг зөвлөмжөөр хангахын зэрэгцээ томоохон 6 суурин газрын халаалтын зуухны үйл ажиллагааг шууд хариуцан ажиллуулж 31563 ГКал/7 сар дулааны эрчим хүч үйлдвэрлэн түгээж, 90 гаруй ажилтантай нийслэлийн нийгэм эдийн зорилтыг ханган биелүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Цэргийн ангиуд, засан хүмүүжүүлэх газруудын 23 зуух төрийн буюу өөрсдийн эзэмшилд ажиллаж байна .

Япон улсын хэрэгжүүлж буй төслийн шугамаар баригдсан ерөнхий боловсролын сургуулиудад суурилагдсан CMNG 0,35 маягийн хятад зуух, Унгар улсын Карборобот маягийн зуух, Монгол инженерүүдийн сүүлийн үед зохион бүтээж буй зуухнууд үнс барих төхөөрөмжтэй ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд утаа цэвэрлэх төхөөрөмжийг ажиллуулах талаар ахиц гарч байна.

Нийслэлийн Засаг дарга, бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2008-2012 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2012 зорилтын хүрээнд Монголын мянганы сорилтын сангийн хөрөнгөөр Хан-уул дүүргийн 22 дугаар халаалтын зуух, Баянзүрх дүүргийн Жанжин клубын “Их засаг” их сургуулийн халаалтын зуух, Сонгинохайрхан дүүрэгт байрлах “Их засаг” сургуулийн, 76, 104 дүгээр сургуулийн тус тус халаалтын зуух, Баянзүрх дүүргийн УС-15 халаалтын зуух, Баянзүрх дүүргийн 102 дугаар сургуулийн халаалтын зуух, Сүхбаатар дүүргийн дулаан техник экологийн хүрээлэнгийн зуух зэрэг зуухнуудын шинэчлэлтийн ажил хийж дулааны эрчим хүчээр найдвартай ханган ажиллаж байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамжаар Баянзүрх дүүргийн 9, 10, 17, 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 6, 68, 79 дүгээр халаалтын зуух, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 117 дугаар халаалтын зуух, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 114 дүгээр халаалтын зуух, Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 46 дугаар халаалтын зуухнуудыг хүлээн авч мэргэжлийн боловсон хүчнүүдээр хангаж, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай ханган ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын 2013 оны А/55 дугаар Захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2013 оны А/68 дугаар Тушаалаар Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Глоб интернэшнл-ийн байруудыг халаадаг нам даралтын халаалтын зуухыг манай байгууллага хүлээн аваад хэрэглэгчдид үйлчлэх бэлтгэлийг хангаж өмч хөрөнгийг хариуцах ажилтныг томилон ажиллуулж байна.

Тус газар нь 2012 онд Нийслэлийн засаг даргын өмнө байгууллагын дүрмээр хүлээлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн, төлөвлөгдсөн ажлуудаа биелүүлж, тайлангийн хугацаанд халаалтын зуухнуудын ашиглалтыг сайжруулах, доголдол, сааталгүй хэвийн ажиллагааг хангах, байгууллагын дотоод ажил, хуримтлагдсан өр авлагыг барагдуулах, үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллаа.